



СЭНДЭНЖАВЫН ДУЛАМ

Төрсөн нутаг:

1950 онд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл: "Цагаан түрүү", "Задын чулуу", "Зүүдний хэлмэр",
"Сэнхрэл уянга" зэрэг яруу найргийн түүвэр хэвлүүлжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:

Монгол бичиг соёлд минь өвөг дээдсийн сүлд онгод оршдог.

“Нүүдлийн цай” шүлэг



- Зураг дээр юу юу дүрслэгдсэн байна вэ?
- Зургаас нүүдлийн ямар заншлыг харж болохоор байна?

НҮҮДЛИЙН ЦАЙ

Нүүдэл, нүүдэл гэж
Гадаа хүүхэд хөөрнө.
Уудал, уудал гэх шиг
Гал дээр цай оргино.
Өнгөрөөд явчих вий гэж
Ээж гэртээ сандарна.
Өрөм зөөхийд хөөрцөглөж
Хийц амтыг нь болгооно.
Өглөөхөн чанасан цай

Домбоны хүзүүгээр халуун ч
Өндөр хангайд зорьсон
Нүүдлийнхэнд шинээр хийцлэв.
Дайн дарсан баатар
Угтах гэж байгаа юм шиг
Дайраад л гарах нүүдлийг
Ээж минь амдан гүйнэм.

(С.Дулам, "Цагаан түрүү" УБ., 1978, 30 дугаар тал)

Дараах үгсийн утгыг
тайлбарлаарай.

- Хөөрцөглөх
- Хийц-
- Домбо-

Ойлгосноо ярилцаж, гол санааг тайлбарлах

1. Шүлгээс мэдэхгүй үгээ түүж бичээд, ойр орчмын үг хэллэгээс нь утгыг таамаглаж олоорой. Толь бичигт тэдгээр үгсийг хэрхэн тайлбарласан бэ? Чиний таамаглалтай таарч байна уу?
2. Ээжийн хийсэн үйлийг тоочин бичээрэй. Эдгээр үйл нь түүний ямар чанарыг харуулж байна вэ?
3. Амдан алхнам эсвэл явнам гэлгүй "Ээж минь амдан гүйнэм" гэж бичсэнийг та нар юу гэж ойлгож байна вэ? Ээжийн сандарсны шалтгаан юу бол?
4. Өглөө чанасан цай халуунаараа байсаар атал ээж яагаад дахин хийцэлсэн бэ?
5. Нүүн ирж буй айлыг шинэ цай барин угтдаг монгол ёс одоо үед байгаа болов уу?
6. Шүлэгт чиний амьдралд хэрэгтэй ямар санаа байна вэ? Та нар яаж хэрэгжүүлье гэж бодож байна?

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Шүлгийн эхний бадагт давтаж байгаа “нүүдал, уудал” гэсэн үгсийг ажиглана уу. Нэг ба гуравдугаар шадыг эхлүүлж байгаа эдгээр үгсийн ижил төстэй авианы давталт нь авианаар дүр бүтээхэд ямар үүрэгтэй оролцож байна вэ?

2. “Дайн дарсан бөөтөр

Угтах гэж байгаа юм шиг

Дөйраад л гарах нүүдлийг

Ээж минь амдан гүйнэм” гэсэн хэсгийн уран дүрслэлийн онцлогийг тайлбарлаарай.

Юуг юутай адилтгаж дүрсэлсэн бэ?	
Ямар шинжээр нь адилтгасан бэ?	

Уран давталтаар
хэний, юуны
ямар шинж
тодорч байна?